



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/138

Есөнбулаг

Аймгийн тэргүүний сум  
шалгаруулж, шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, 4.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 113 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн шагналын журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.8, 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэг, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 6 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :


1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020-2025 оны үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тэргүүлэх чиглэлийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд манлайлан ажиллаж, шинэлэг ажлуудыг санаачлан бодит үр дүн гаргасан сумдыг аймгийн "Тэргүүний сум"-аар шалгаруулан, нэрсийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дагалдах мөнгөн шагналын 6,435,000 (зургаан сая дөрвөн зуун гучин таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Тэргүүний сумаар шалгарсан сумдын Засаг дарга нарыг нэг сарын үндсэн цалингаар, хамт олныг байгууллагын төсөвтөө багтаан урамшуулахыг төсвийн шууд захирагчдад зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:\My document\ZAX A-4

8200010568




Аймгийн Засаг даргын 0004 тоны  
02 дугаар сарын 02 ны өдрийн 02 дугаар  
захирамжийн 01 дүгээр хавсралт

ТЭРГҮҮНИЙ СУМ 00000042

1. Сумдын шинэчлэл, хөдөөгийн хөгжил хөтөлбөрийг түүчээлэгч (Тонхил сум)
2. Ерөнхий боловсролын сургалтын түвшингээр олон улсад үнэлэгдсэн (Алтай сум)
3. Эко сум, Шинэ суурьшлын төлөвлөлтөөр түүчээлэгч (Цээл сум)
4. Газар тариалан, жимс жимсгэнэ хөтөлбөрийн тэргүүлэгч (Халиун сум)
5. Сумын төвийн гэрэлтүүлэг, тохижилтоор манлайлагч (Дэлгэр сум)
6. Хамгийн их бүтээн байгуулалтуудыг хэрэгжүүлэгч (Есөнбулаг сум)
7. Нэг тэрбум мод тарьж ургуулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймагт 108 сая мод тарьж ургуулах арга хэмжээг манлайлагч (Цогт сум)
8. Аялал жуулчлалын аймгийн батлагдсан хөтөлбөрийг хамгийн сайн хэрэгжүүлэгч, түүчээлэгч (Жаргалан сум)
9. Иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах орчныг бүрдүүлсэн түүчээлэгч (Чандмань сум)
10. Төрийн шилдэг менежмент, зохион байгуулалттай (Эрдэнэ сум)
11. Брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэгч сумаар (Хөхморьт сум)-ууд тус тус шалгарсан болно.

\_\_оОо\_\_

Аймгийн Засаг даргын *2011* оны  
*02* дугаар сарын *08* -ны өдрийн *13* дугаар  
захирамжийн *02* дугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

| №  | Зардлын нэр            | Нэгжийн үнэ | Сумдын тоо | Нийт      |
|----|------------------------|-------------|------------|-----------|
| 1. | Өргөмжлөл              | 75,000      | 11         | 825,000   |
| 2. | Дагалдах мөнгөн шагнал | 500,000     | 11         | 5,500,000 |
| 3. | Батламж                | 10,000      | 11         | 110,000   |
| 4. | Нийт мөнгөн дүн        | 585,000     | 11         | 6,435,000 |

\_\_оОо\_\_